

ХАНЬ УЛСЫН ЦЭРГИЙН АГТНЫ ТӨЛӨӨХ ДАЙН

Б.БАТЖАРГАЛ

Товч агуулга: Хань улс Хүннүгийн цэргийн харилцааны хамгийн гол хөдөлгөгч хүч нь цэргийн агт морьд байсан юм. Дайны ажиллагаа бүрийн үр ихэнх тохиолдолд цэргийн агтаас хамаарч байсан аж. Хань улс Хүннүгийн цэрэг дайны тухай судалгааг эрдэмтэн судлаачид ихээхэн анхаарч судласан боловч цэргийн агтын тухайд тусгайлсан судалгаа, өгүүлэл гараагүй дам байдлаар дурдагдсан нь асар их ажээ. Бид энэхүү өгүүлэлдээ Хань улсын Уди хааны Хүннү даран сөнөөх зорилгынхоо нэгээхэн хэсэг шандаст хүлэгтэй болох зорилт байсан тухай өгүүлэх юм. Дээрх зорилгын хүрээнд “хугийн адуу” (胡马 hu ma), “тэнгэрийн хүлэг” (天马 tian ma), “цусаар хөлөрдөг адуу” (汗血马 han xue ma) зэрэг шилдэг угшилын адууны төлөөх тэмцлийн тухай өгүүлэх болно.

Түлхүүр үг: Хүннүгийн баруун гарыг таслах бодлого, цэргийн агт, хугийн адуу, тэнгэрийн хүлэг, цусаар хөлөрдөг адуу

Д.ЖВернадский “Морийг талын нүүдэлчдийн амьдралын гол хэрэгсэл, армийн үндсэн хүч гээд монгол хүн, морь хоёрын аль аль нь эцэх цуцахыг мэдэхгүй хоол хүнсээр дутагдахад алзахгүй тэсвэртэй”¹ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Хүннүгийн адууны үүлдэрийн талаар эрдэмтэн С.И.Руденко “Хүннүгийн булшнаас олдсон ясны байдлаас үзэхэд нийтдээ ердөө монгол сүргийн адуу байв. Богинохон бумбагар хошуутай, памбагар бүдүүвтэр боловч шөрмөслөг биетэй намхан нуруутай байв”² хэмээн дүгнэсэн байна.

Хань улсын эхэн үед цэргийн агт цөөн, хомсдолтой байсан ажээ. Энэ тухай “Түүхэн тэмдэлэл, Пин Юуны бичиг”-т тэнгэрийн хөвгүүний сүйх тэргэнд холбох зүс ижил морь олодохгүй тул ижил зүсмийн үхэр хөллөж байв”³ гэсэн байдаг.

Хань улсын үүсгэн байгуулагч Гао-Ди (高帝 gaodi) НТӨ 200 онд анх удаагаа нүүдэлчидтэй 320 мянган цэргийн хүчээр байлдаж, бүслэгдэв. Байлдааны

¹ Нацагдорж, Ш. *Чингис хааны цадиг*, Улаанбаатар: 1991, 215

² Руденко, С.И. *Культура хуннов и Ноинулинские курганы*, М.-Л., 1962, 24

³ 史记(shi ji), 第30卷, 第1417页

ажиллагаа анхандаа амжилттай явагдаж байсан бөгөөд Ма И-гийн бэхлэлтээс Пинчэн хүргэл амжилттай байлдаж ялалт байгуулсан боловч санаанд оромгүй зүйлтэй нүүр тулжээ. “Түүхэн тэмдэглэл, Хүннүгийн шастир”-г ”Хань улсын цэрэг Модуныг хөөн дайрав. Модун шилдэг цэргээ нууж сул буурайг үзүүлэв. Хань улсын цэрэг хөгшин зэмдэг олонтой байжээ. Явган цэргээр голлон гучин хоёр түм байлаа гэдэг. Хойноос нь нэхэв”¹. Пинчэнд, тэд маш богино хугацаанд Хүннүгийн морин цэрэгт бүслэгдсэн бөгөөд Хань улсын цэргийг зүс ижилдүүлсэн дөрвөн зүсмийн морьт цэргээр дөрвөн зүгээс хааж бүсэлсэн байна. Тэднийг зүс ижилдүүлсэн саарал зүсмийн морьт цэргээр баруун талаас нь, хээр зүсмийн морьт цэргээр зүүн талаас нь, хар зүсмийн морьт цэргээр умард зүгээс нь, зээрд зүсмийн морьт цэргээр өмнөд зүгээс нь хааж, бүсэлсэн байдаг². НТӨ 200 оны байлдаанаас үзвэл, Хань улс цэргийн агтаар дутагдалтай, армийн ихэнхийг явган цэрэг эзэлж байв.

Давшилтын үеэр Хүннүгийн цэрэг давхиж буй морин дээрээс төвөггүй харваж буйг хараад балмагдаж, бас нөгөө талаар чадварлаг, хүчирхэг гавшгай морин цэрэгтэй болох бодол төрсөн болов уу. Энэ л түүхэн үеэс Хань улс цэргийн агт өсгөхөд ихээхэн анхаарал хандуулж, төрийн бодлогоор адууг их хэмжээгээр өсгөх болсон байна. Цэргийн агт, түүнийг чадмаг эзэмших цэрэг дайчдыг олон тоогоор бэлтгэх асуудал Хань улсын хааны ордонд өрнөх болсон³.

Вэньди (НТӨ 203-157), Жинди (НТӨ188-141), Уди (НТӨ 141-87) хаан адуу өсгөх бодлогыг тодорхойлж, цэргийн агтанд зориулж ард иргэдээс татвар авах болсон байна. Цэргийн агт хамаарах газар байгуулж, хариуцсан түшмэл томилж, хэдэн арван туслах, түшмэдийн хамтаар улсын адуу үржүүлэх ажлыг хариуцаж байв⁴. Жинди хааны үеэс адуу үржүүлэх 36 хороо газарт, 300,000 (30 түм) орчим цэргийн агт (гүү, унага зэргийг оруулаагүй) өсгөхөд зориулан 30,000 гаруй түшмэл, цэрэг, боол, зарц ажиллаж байсан аж⁵. Уди хааны үед Хань улсын цэргийн агт 400,000 хүрсэн⁶ тухай түүхэн сурвалжид тэмдэглэсэн байна.

Уди хаан хаан адуу өсгөх бодлогын хүрээнд хэрэглэгдэх зардлыг бүрдүүлэх сан байгуулсан. МЭӨ 203 он 8 сард тусгай татвар “算赋 shuan fu” авч эхлэв. Дээрх адуу үржүүлэх сангийн татварын талаар Гожугийн иш татсан “Хань улсын ёслолын тайлбар”-г

¹ 史记(shi ji)第110卷. 第2894页

² 史记(shi ji), 第110卷, 第2894页

³ 史记(shi ji), 第30卷, 第1419、1420页

⁴ 史记(shi ji), 第30卷, 第1417、1418、1419、1420页

⁵ 如淳曰：汉仪注：太仆牧师诸苑三十六所，分布北边、西边，以郎为苑监，官奴婢三万人，养马三十万匹。

⁶ 《通典·职官·诸卿上》太仆卿注。

“...арван таваас дээш тавин зургаа хүртэлх насны ард, алба тушаан, зуун хорин хүнийг нэг хэмээн тооцож татвар авна. Уди хааны үед цэргийн агтанд зориулан гурван чан зоос нэмж хураав. Үүнийг адууны тэжээлийн зоос гэдэг...”¹ хэмээн тэмдэглэсэн байна.

Адуу хамаарах газрыг Тайфу түшмэлээр хамааруулж, түүнд туслах Тайфу чен түшмэл, Ма заолин, У буюу Чан, Цуй зэрэг тушаалыг бий болгов. “Хань улсын хуучин ёслол” бичгээс харахад Тайфугийн захиргаанд тэнгэрийн хөвгүүний зургаан адууны хороо (Вэй ян, Чен хуа, Чима, Лу болон да жи) байжээ². Бусад түүхэн сурвалжаас үзвэл “Циу Хуа, Дагө, Вэйго, Элян, Даён, Хухэ, Жинжи, Жама” зэрэг адуу тэжээх хороо³ байгуулагдаж байсан.

Вэньди хаан чөлөөт ардыг урамшуулж, адуу өсгөх зарлиг (复马令 fu ma ling) гаргажээ. Мөн цэрэг татлагын хуулинд өөрчлөлт оруулж, адуунд хөллөх нэг тэрэг, нэг мориор гурван хүнийг цэргийн албанаас чөлөөлөх зарлиг гаргасанаар Хань улс даяар адуу үржүүлж, цэргийн албыг мориор дүйцүүлэн хаах тохиолдол газар авчээ. 16-56 нас хүртлэх иргэн бүрээс адуу үржүүлэхэд зориулж, зоосны татвар хураах болсон байна⁴.

Адуу, үхэр алж, нядлах, хулгайлахыг хатуу хориглосон зарлиг гаргаж байжээ. Тухайлбал, Жу Янь-аас олдсон хулсан бичгэн дээр “...албан тушаалтнууд зарлиг бичгийн дагуу адуу, үхэр нядлаж үл болно...”⁵ хэмээсэн бол, “Давс төмрийн шүүмж” бичгийн эрүүгийн бүлэгт”, “...адуу хулгайлагчийг цаазал, үхэр хулгайлагчийг хүндээр ялал...”⁶ хэмээх заалт буй аж.

Дээрх мэдээнээс үзэхэд, адуу өсгөх, үржүүлэх ажлыг төрийн бодлогын түвшинд авч хэрэгжүүлж байсан бөгөөд харц ардууд адуугаар цэргийн албыг дүүцүүлж болох тухай зарлиг гаргаснаар улс даяар адуу өсгөх болжээ. Мөн адуу үржүүлэхэд шаардагдах санхүүг бүрдүүлэх зорилгоор, тусгай татвар ард иргэдээс хурааж байсан аж. Бүх нийтээр адуу өсгөх бодлогын хүрээнд адууг гадагш худалдаалахыг хориглох, тусгай зөвшөөрлөөр адууг алж нядлах болж,

¹ 如淳注引《汉仪注》曰：“民年十五以上至五十六出赋钱，人百二十为一算”，至武帝时又口加三钱，“以补车骑马”，此所谓马口钱。

² 设置和健全了马政的管理机构，命太仆(武帝时改为仆)专管养马事务，下设太仆丞，以及下属马厩的令、丞或长、垂。据《汉旧仪》：太仆所掌的“天子六厩”：未央、承华、骑马、路和大厩。

³ 其它散见于史籍的厩名有翠华、大格、果卫、扼梁、大宛、胡河、金厩、家马等。

⁴ 如淳注引《汉仪注》曰：“民年十五以上至五十六出赋钱，人百二十为一算”

⁵ 劳干《居延汉简考释》(一一六)一七〇·三号简：“府移使者口所诏书，毋得屠杀牛马。”

⁶ 王贞珉《盐铁论注译》，1990年，吉林文史出版社，第269页

зөвшөөрөлгүйгээр адуу алж, нядлахыг хатуу хориглож, адууны хулгайчийг цаазалж байв¹.

Тухайн үеийн Хань улсын ардууд адууг ихээр тэжээж байсан тухай түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн байна. Тухайлбал, “Давс төмрийн шүүмж, үл нэвтэрхүй бүлэг”-т “Үхэр, адуу сүрэглэн бэлчиж, адууг газар хагалахад зүтгүүлэх болов. Морь үгүй өрх (баян Ба.Б) гэж үгүй болов” хэмээн тэмдэглэсэн байна². Мөн “Түүхэн тэмдэглэл, Пин Жүнгийн бичиг”-т “... олон ард, адуу тэжээх болов...” гэх мэт адууны тухай сурвалжийн мэдээг хэдэн арваар дурдаж болохоор байна.

Гэвч улс даяар маш их хөрөнгө, хүч зарцуулж өсгөж буй уг агт морьдын ач холбогдол үр өгөөжийн тухайд цэргийн түшмэд болоод Хань улсын хаад ямагт сэтгэл дундуур байжээ.

Хань улсын цэргийн шилмэл агт, морьд нь, Хүннү улсын цэргийн агт морьтой энэ зэрэгцэж чадахгүй байгаа болон хүнс хоол, арчилгаа их шаарддаг бөгөөд хатуужилгүй байгаад үргэлж сэтгэл зовниж байв. Энэ тухай “Хань улсын бичиг Яо Цо-гын намтарг “цэрэг, байлдааны алдагдалыг өгүүлэхүй” хэмээх айлтгалд

“Хүннү улсын газрын байршил нь сонин жигтэй, Хятадаас өөр ажээ. Хүннү цэргийн морьтой адил уулын хамраар явж, ус голоор гатлах, хавцал, хөтлөөр шургаж, харваж довтлоход Хятадын морь яавч чадахгүй аж”³

хэмээн тэмдэглэсэн байна. Хүннү цэргийн агт тэсвэр, хатуужилтай бөгөөд Хүннүгийн ард түмэн, бүх нийтээр адууг эдэлж, хэрэглэж, ус өвсийг тохируулж чаддаг гойд эрдэмтэйг бахархан тэмдэглэсэн хэрэг аж.

Тухайн үеийн Хань улсын агт морьд аян дайнд өл даах чадвар, тэсвэр хатуужилаараа умард нутагт цэргийн томоохон ажиллагаа явуулахад тэнцэхгүй байсан бөгөөд Хүннү цэргийн агт морьтой олон талаар эн зэрэгцэхгүй байгааг тэд мэдэрч байсныг дээрх мэдээлэл баталж байна.

Тэд анхандаа агтны тоонд анхаарч байсан бол Уди хааны үеэс сайн үүлдрийн цэргийн агттай болох бодлогыг улс даяар хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Уди хаан Хүннүгийн нутаг руу цэрэг илгээхдээ байлдааны ажиллагааны амжилт цэргийн агтны хангалтаас шууд хамаарна гэдгийг ойлгож, энэ асуудалд ихээхэн анхаарал тавьж байв. Тухайлбал, “Хань улсын бичиг, Хүннүгийн шастир”-т дурьдсанаас үзвэл, ”Дараа оны хавар нь Хань улсаас «Ван хоу шинь Шаньюйд арга заан цөлийн хойгуур нутаглавал Хань улсын цэрэг ирж чадахгүй хэмээн санаж буй» гэж

¹ 劳干《居延汉简考释》(一一六)一七〇・三号简：“府移使者口所诏书，毋得屠杀牛马。”

² 王贞珉《盐铁论注译》，1990年，吉林文史出版社，第86页

³ 汉书(han shu)，第49卷，第2279页

зөвлөж байсан тул шар будаагаар агтсаа гэжээв. Арван түмэн агт бэлтгэв. Өөрийн бэлтгэсэн агт морь арван дөрвөн түм болов. Амуу хүнс, ачаа тоогүй болов”¹ гэжээ.

НТӨ 121, 119 оны байлдааны ажиллагаанд Хань улс амжилт олсон ч энэхүү байлдаанд 100 гаруй мянган цэргийн агтаа алдсан нь Хань улсын хувьд том гарз болж, Ханьгийн арми цэргийн агтаар дутагдаж, томоохон хэмжээний цэргийн ажиллагаа явуулах боломж хязгаарлагдах болсон². Иймд тэд Хүннү улс болон бусад улс орноос сайн үүлдрийн адуу авах боломж бололцоог шаргуу судлах болсон байна.

НТӨ 113 оны намар Дунгуанд³ цөлөгдсөн Бао Личан гэх ялтан, тэр нутгаас сайн үүлдрийн агт барьж Уди хаанд бэлэг болгон өргөсөнд Уди хааны сэтгэлийг ихэд хөдөлгөсөн тул тэнгэрийн адуу (天馬 tian ma) хэмээн нэрлэж, дуу зохион дуулжээ. “Түүхэн тэмдэглэл, дууны бичигт”,

“...Тай И одон сахиус тэнгэрийн адууг бидэнд бэлэглэв. Бүтэн биеэс нь улаан хөлс асгаран, буржигнасан хур адил хөөсрөн дуслан, Хурдлах гүйдэлээс нь үзвэл түмэн газрыг эвхмээр, Хорвоогийн сайн цагаар луу ханьсах болов...”⁴

хэмээн дуулсан гэдэг. Дунгуаны адууг “Хуучин Тан улсын бичиг, Түгүхүний шастир”-т

“...Чинхай далай бий. Эргэж тойроод найман зуун ли байна. Дунд нь жижигхэн уултай. Өвөл болоход түүнд гүү тавина. Луугийн унага авна гэж хэлдэг. Персийн адууг хамт оруулан... төрсөн саарал унага нь өдөрт мянган ли гүйнэ гэнэ. Чинхайн саарал хэмээн үе дамжин нэрлэдэг ажээ...”⁵

хэмээн тэмдэглэсэн байна.

Дээрх мэдээнээс үзэхэд Дунгуаны адуу нь персийн адуутай эрлийзсэн, угшил сайтай адуу байж. Уг хүлгийг үзээд Уди хаан баярласандаа дуу зохион дуулснаас үзэхэд тухайн үедээ үнэхээр сайн адуу байсан бөгөөд Уди хаан цэргийн агтант ихээхэн анхаарал тавьж байсныг харуулж байна.

Түүний дараа Юэжийн вантай холбоо тогтооох зорилгоор баруун хязгаарт Жан Цянийг элчээр илгээсэн бөгөөд тэрээр 13 жилийн дараа баруун хязгаарын орнуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй ирсэн байна. Уг мэдээлэлд “...Даваньд “цусаар хөлөрдөг” адуу буй бөгөөд тэсвэр хатуужил, үнэнхүү сайн”⁶ хэмээхийг

¹ 汉书(han shu).第94卷.第3769页

² Дэлгэржаргал, П., Батсайхан З. *Монголын эртний түүх: Хүннү*. Тэргүүн боть. Улаанбаатар: 2017, 112

³ Одоогийн Хөх нуур орчмын нутаг.

⁴ 史记(shi ji), 第24卷, 第1178页

⁵ 旧唐书(jiu tang shu), 第198卷, 第5297页

⁶ 史记(shi ji), 第123卷, 第3160页

Уди хаан сонсоод их хэмжээгээр авч ирж, тэжээхээр элч илгээсэн байна¹.

“Хань улсын бичиг”-ийн “Жан Цянь, Ли Гуанлийн намтар”-т

“...Анх тэнгэрийн хөвгүүн “И зурхай”-г шүүж төлөгдөхөд “сахуусны адуу баруун хойноос ирнэ” хэмээн төлөг буув. Усуны адууг олоод мөн тэнгэрийн адуу хэмээн нэрлэв. Хожим Дунгуан, Даюань-ны адууг олов. Хүчтэй чийрэг байв. Иймд Усуний адууны нэрийг өөрчилж “баруун хязгаарын адуу” хэмээн нэрлэв. Даюань адуу давхихдаа цусаар хөлрөх тул “цусаар хөлөрдөг адуу”, Дунгуаны “тэнгэрийн адуу” хэмээх нэрлэв...”²

гэж тэмдэглэсэн байна.

Хань улсаас зуу гаруй элчийн баг бүрдүүлэн амьд морины хэмжээтэй алтан цутгамал морь хийж, Даваний ванд бэлэглэж. Хариуд нь “цусаар хөлөрдөг” адуу, азарга их хэмжээгээр авахуулахаар элч илгээжээ. Даваний вантай нь золгож учраа өгүүлэхэд зөвшөөрсөнгүй.

Тус хэргийн талаар Хятад сурвалжид “...Хань улс биднээс асар хол. Далайн ус өнгөрөхөд хэдэн удаа үхэж үрэгдэнэ. Умард нутагт Хүннү улс буй, өмнөд нутаг ус өвс байхгүй, бас хот суурин байхгүй, хоол хүнсээр гачигдах нь лавтай. Хань улсын хэдэн зуун элчийн баг хүнсээр дутагдаад хагас илүү нь үхдэг. Иймд их цэрэг ирж чадах эсэх нь эргэлзээтэй... Арши(貳师)-ийн адуу болвоос Даюань-ны эрдэнэ болой. Өгч яаж болох” хэмээгээд өгөх боломжгүй тухай учирлан хэлэхэд Хань улсын элч хилэгнэн уурлаж, дээрэнгүй үг хэлж, алтан морио ачаад явжээ³.

Даюань-ны түшмэд нь уурлаж “Хань улсын элч биднийг доор үзэж байна” гээд Хань улсын элчийг хөөн гаргав. Зүүн зүгт байгаа Ю Чуан ванд элч илгээн тосож, дээрэмд хэмээжээ. Хятадын элчийн нар буцах замдаа дээрэмчидтэй учирч, алтан морь нь булаагдаж, ахлах элч нь ч амиа алдав⁴. Энэ хэргээс улбаалан Уди хаан уурлаж, “эвээр авья хэмээхэд өгдөггүй юм бол булаагаад авч ир”⁵ хэмээн зарлиг буулгажээ. Ийнхүү сайн угшилын адууны төлөөх баруун хязгаарын дайн эхлэв.

НТӨ 104 онд Ли Гуанли жанжныг зарлигдан хэдэн түмэн цэрэгтэй мордуулав. Ли Гуанли “зургаан мянган шилдэг морьт цэрэг, жүн улсын танхай залуучуудаас бүрдсэн хэдэн түмэн цэргийн хүчээр Даюань дайлахаар мордов. ... Ши хотод хүрч сайн адууг булаан авахаар тооцоолсон учир ... Ли Гуанлиг Арши(貳师将军) жанжин хэмээн нэрлэв. Ли Гуанлигийн удирдсан цэрэг зам дагуу хоол, хүнсээр

¹ 史记(shi ji), 第123卷, 第3170页

² 汉书(han shu), 第61卷, 第2693-2694页

³ 汉书(han shu), 第61卷, 第2697、2698页

⁴ 汉书(han shu), 卷123, 第3174页

⁵ 汉书(han shu), 第61卷, 第2697、2698页

хавчигдаж, ядарсаны учир Даюань хүрч чадалгүй Ючэн хотод хүрч, тус хотыг эзлэхээр дайлдсан боловч их ялагдаж, нийт цэргийнхээ арван хүн тутмын ес нь үхэж, шархаджээ. Энэ мэтээр зууралдан байлдах нь ашиггүй тул Дунхуаньдаа буцсан байна¹.

Ли Гуанли жанжин хуандид элч явуулан “зам асар хол учир хүнс хоолоор гачигдав, цэрэг байлдаж, зовсонгүй, өлсгөлөнд их зовов. Мөн цэрэг цөөхөн учир Даюань-ийг байлдаж авч чадсангүй. Түр ухарч цэргээ нэмээд ахиад мордохыг гуйнам” гэжээ. Үди хаан үүнийг сонсоод их уурлаж, Ли Гуанли-д элч явуулан Юмэн боомтод цэрэг захиран суух зарлиг буулгажээ².

“Түүхэн тэмдэглэл”-ийн “Жан Цянь, Ли Гуанлийн намтар”-т “... Хэргэмтэн, түшмэд зөвлөлдөөд Даюань-ийг дайлахаа больж хүч нийлүүлэн Хүннү улсыг дайлъя гэв. Үди хаан “Даюаньд нэгэнт цэрэг илгээсэн билээ. Даюань мэтийн жижиг улсыг ялж чадахгүй болвоос Дася мэтийн том улс Хань улсыг тоож ч үзэхгүй болно. Даюань сайн үүлдрийн адуу авч ирэхгүй болвоос Усунь (乌孙), Лунтай (轮台) зэрэг улс Хань улсын элчийг дорд үзэж, харь улсын инээдэм болном бишүү” хэмээгээд Даюаныг дайлж болохгүй гэсэн Жэн Гуан гэх мэт түшмэдийг залхаан яллав³.

Гэмт хэрэгтэн хулгайч дээрэмчнийг өршөөж, танхай залуучууд болон хилийн цэргийг нэмэн татаж, жил гаруй дайны бэлтгэл хийсний эцэст Дунгуанаас зургаан түмэн цэргээс гадна сайн дураараа дагасан цэргүүдийн бүрэлдэхүүний хамт Даюань руу хөдлөв⁴. Цэргийн хүнсэнд үхэр арван түмэн, адуу гурван түмэн, элжиг, тэмээ хэдэн түмэн буй, амуу хүнс, зэр зэвсэг, нум сум гээд бэлтгэл сайтай байлаа” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Даюаний дайны бэлтгэлийг бүх улсаараа хөдөлцгөөж ар араасаа дайныг дэмжсэн байна. Их цэргийн бүрэлдэхүүнд л гэхэд тавин хэдэн сяовэй жанжин⁵ Ли Гуанлид туслалж байв. Арван найман түмэн хуягт цэргийг Жю Цюнь, Жан Юэ хотын хойгуур нэмж томилон Жиу Янь, Шиу Ту-д суулгаж, Жю Цюнь (酒泉 jiū quán, одоогийн Ганьсу Жю Цюнь хот орчим) хотын хамгаалалтыг бэхжүүлсэн. Хань улсыг харьяат улсуудаас долоон төрлийн хууль зөрчсөн гэмтэн болон цэргийн хуурай хүнсээр ... Ши жанжинд туслав. Тэрэг хөлөглөн тээвэр хийх

¹ 汉书(han shu), 第61卷, 第2699页

² 汉书(han shu), 第61卷, 第2699页

³ 汉书(han shu), 第61卷, 第2699页

⁴ 汉书(han shu), 第61卷, 第2701页

⁵ Сяо Вэй 校尉 xiao wei, Жун Лан Жян 中郎将 zhong lang jiang, Жанжин 将军 jiang jun буй. Сяо Вэй нь байнга байдаг, нөгөө хоёр нь байнга бус.

хүмүүсийн цуваа Дунхуань хүртэл үргэлжилж байв. Бас морь шинждэг хүнийг адуу дагах Сяовэй түшмэл болгож Даюанийг эзэлсний дараа сайн үүлдрийн адууг авахад бэлтгэсэн байна¹.

НТӨ 102 онд Ли Гуанли Ар Ши жанжин их цэрэг удирдан Даюань руу давшив. Зам дагуух жижиг улсууд угтан ирж, их цэрэгт хүнс нэмэрлэв. Лүнтай хүрэхэд Лүнтай дагасангүй тул хэдэн өдөр байлдаад тэднийг хядсан. Үүнээс баруун тийш Даюань хүртэл амар амгалан явсаар Даваний нийслэлд Хань улсын гурван түмэн цэрэг хүрсэн байна. Даюаний цэрэг нь Хань улсын цэргийг угтан байлдсан ч ялагдан зугтаж, хотоо бэхлэн суужээ. Даюаний нийслэл хотын дотор устай худаг байхгүй, хотын гаднаас ус татдаг байв. Ли Гуанли усны урсгалыг өөрчилсөнөөр хот усгүй болгов. Даюань хотыг бүсэлж, дөчин хэдэн өдөр байлдсаны эцэст хотын гадуурх хэрмийг эвдэж, Даюаний баатар жанжин Жяо Пэйг барьжээ. Даюаньчууд ихэд сүрдэж хотын дотор хэрмийг хамгаалан суув. Даюаний сайд түшмэдүүд нөхцөл байдлыг хэлэлцэж, “Хань улсаас Даюанийг дайлж байгаа нь манай ван Угуа-аас болжээ” гэгцгээв. “Манай ван Угуа сайн үүлдрийн адууг нууж, Хань улсын элчийг алав. Одоо ванг алж сайн үүлдрийн адууг өгвөөс Хань улсын цэрэг бүслэлтээ цуцалж буцах нь магад. Үгүй болвоос байлдсаар үхсэн ч яахав, оройтохгүй” гэсэнд Даюаний ноёд бүгдээр зөвшөөрч, вангаа алж, тэргүүнийг нь бариулан элч явуулж ... ши жанжинд хүргүүлэв². Даюаний элч “Хань улс цэргээ татвал, сайн үүлдрийн адуугаа гаргая, та нар дураараа сонгон авцгаа, цэргийн хүнсийг ч бас өгье. Бидний үгээр болохгүй болвоос сайн үүлдрийн адуугаа бүгдийг нь алах болно. Канжү-гийн туслах цэрэг удахгүй ирнэ. Тэд ирвээс бид дотроос нь Канжү гаднаас нь Хань улсын цэрэгтэй байлдах болно. Арга ийм байна, яахаа өөрсдөө мэд³” хэмээн найрамдах санал тавьжээ.

Ши жанжин Даюаньчууд хотын дотор худаг гаргасан бөгөөд хүнсний нөөц хангалттай байгаа гэсэн мэдээ сонссон байв. Тиймээс бид энэ удаа ван Угуаг алахаар ирсэн билээ. Угуан нэгэнт тэргүүнгүй болжээ. Эдүгээ цэргээ татахгүй болвоос тэд хэрмээ бэхлэн сахих болно. Канжү мэтийн улс Хань улсын цэргийн хүч сулдмагц Даюаньд туслах магад. Тэр үед байлдаас Хань улсын цэрэг лавтай ялагдах болно⁴ хэмээн Хань улсын цэргийн жанжид ярилцаад, Даюаний найрамдах саналыг зөвшөөрөв. Хоёр тал хэлэлцэн тохиролцсоны дагуу Даюаньчууд адуу, цэргийн хүнс гаргаж өгөв. Хань улсын цэрэг хамгийн сайн шилмэл адуунаас

¹ 汉书(han shu), 第61卷, 第2701页

² 汉书(han shu), 第61卷, 第2701页

³ 汉书(han shu), 第61卷, 第2701页

⁴ 汉书(han shu), 第61卷, 第2701页

азарга, гүү гээд арав гаруй, дунд зэргийн адуунаас гурван мянган азарга, гүү сонгож аваад буцжээ. Нутгийнхаа хилд хүрэхэд, авч гарсан адуунаас нь мянга илүү үлдсэн байв¹.

Даюаний адууг олсоноор Уди хаан урд хожид байгаагүйгээр баярлаж, мөн дуу зохион дуулжээ. Түүхэн тэмдэглэл, хөгжмийн бичиг”-т

“...Тэнгэрийн хүлэг баруунаас ирэв.

Түмэн газрын товчилсон туурайн төвөргөөн үүлэнд дүүлэх мэт

Гадаад улсыг төвшигтгөв.

Ганга, элсэн цөлийг туулж, дөрвөн харийг номхотгов...”²

хэмээн дуулж байсан байна.

Хятадууд Хүннүгийн адууг “Ху-ын адуу” (胡马 hu ma), Дунгуанаас авсан адуугаа “тэнгэрийн адуу” (天马 tian ma), Усунь-ээс авсан адуугаа “баруун хязгаарын адуу” (西极马 xi ji ma), Даюань-аас авсан адуугаа “цусаар хөлөрдөг адуу” (汗血马 han xue ma) гэж ялган салган нэрлэж байв. Дээрх мэдээнээс үзэхэд Хань улсын хаад шилдэг сайн цэргийн агттай болохыг ихэд хүсэмжилж байсан бөгөөд Чаньань хотоос Даюань улс хүртэл 2500-3000 км газар их цэрэг аялуулж байсан нь дайны бэлтгэл хангахад цэргийн агт ямар их хэрэгцээтэй байсныг илтгэх аж.

Уди хааны үед ард иргэдээс цэргийн албыг цэргийн агтаар дүүцүүлэхийг зөвшөөрч байсан нь Ханьгийн цэргийн агт богино хугацаанд өсөхөд үлэмж нөлөө үзүүлсэн байна. Ард иргэд ч цэргийн албанаас чөлөөлдөхийн тулд адуу өсгөх болсон ажээ. Цэргийн албыг нэг морь, моринд хөллөх нэг тэргээр 3 хүнийг цэргийн алба хааснаар дүйцүүлж байсан тухай сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. Цэргийн агт өсгөх төрийн бодлогын үр дүнд Хань улс их хэмжээний агт морьтой болсон байна. Ийнхүү хүчирхэг морьт армитай болох Уди хааны зорилго биелсэн боловч Хүннүтэй хийх дайнд Хань улсын цэргийн агтын хангалтын хувьд Хүннүтэй өрсөлдөж чадахгүй байв.

Хуанди Хүннүг дайлахийн төлөө их хэмжээгээр адуу өсгөн, нийслэлийн хот Чаньанд хамгийн ихдээ хэдэн арван мянган адуу өсгөж байв³. Зөвхөн Уди хааны үед Хүннүтэй хийсэн их дайны явцад Хань улс 1.200.000 гаруй цэргийн агтаа жагсаалаас гаргасан бөгөөд их дайны дараа гэхэд Хань улсын цэргийн агт, гүү нийлээд нийт 200 мянга хүрэхгүй болсон байв.

¹ 汉书(han shu), 第61卷, 第2701页

² 史记(shi ji), 卷24, 第1178页

³ 史记(shi ji).第30卷.第1425页

Хань улс нүүдэлчдийн, тухайлбал, Хүннү нараас морьт цэргийн байлдааны тактик, адуу өсгөх арга технологиос суралцсан хэмээн үзэж болно. Тухайлбал, Хунань мужийн Чаньша хотын Ма ван дуй-н Хань улсын I-р бунханаас олдсон торгон дээр бичсэн морь шинжих судар (相马经, одоо Хунань мужийн музейд хадаглагдаж байна)-т сайн морь шинжих үндэс, толгой шинжих, нүд шинжэхүй, чих шинжихүй, хамар шинжихүй, ам шинжихүй, ясны байдлаар шинжлэхүй, туурайн шинжих..гэх мэт олон шинжийн талаар өгүүлсэн байдаг. “Хань улсын бичиг, Хогуанг Жинмидийн намтар”-т “Хүннүгийн баруун ван Сюту ван (休屠王 Xūtu tú wáng)-ийн хөвгүүн “Жинмиди төрийн адууны газар ажиллаж байгаад, адуу сайн өсгөснөөр төрийн адууны газрын ахлагчаар томилогджээ. Хожим нь Ци жунг, Фумадувэй, Гуанглу дафу түшмэл болжээ”¹ гэсэн буй. Тэгэхээр Хань улсын үед Хятадын төв бүс нутагт Жинмиди шиг Хүннү гаралтай хүмүүсийг цэргийн агтны түшмэлээр томилж, тэдний адуу маллах эрдмээс суралцдаг байсан ажээ.

Ерөнхийлөн дүгнэж үзвэл, НТӨ 200 оны үе гэхэд, Хань улс цэргийн агтаар дутагдалтай, армийн ихэнхийг явган цэрэг эзэлж байв. Сурвалжид дурдсанаар Жинди хааны үед адуу хамаарах газар болон адуу үржүүлэх 36 хороонд түшмэл, цэрэг, агтчин, зарч боол нар нийт 30,000 гаруй хүн ажиллаж байсан байх юм. Уди хааны үед 400,000 мянган цэргийн агттай болсон байна. Мөн агт өсгөхөд шаардагдах хөрөнгийг ард иргэдээс татан авч сан бүрдүүлж, адуу хамаарах газар (马政 ma zheng) байгуулж байжээ. Хэдэн мянган хүн томилон ажлуулж байв. Мөн улс даяар адуу өсгөхийг уриалж, цэргийн албыг адуугаар дүйцүүлэн хаалгаж байжээ. Уди хааны Хүннү гүрэнтэй хийсэн их дайнд тэд 1,200,000 цэргийн агтаа сүйтгэсэн байна. Ханьгийн арми цэргийн агтны дутагдалд орж, Хүннүгийн эсрэг томоохон цэргийн ажиллагаа явуулах боломж хязгаарлагдах болсон. Уди хааны Баруун бүс нутагт хийсэн байлдааны ажиллагааны нэг зорилго нь цэргийн агтны нөөцөө бүрдүүлэх явдал байв. Цэргийн шилдэг адуутай болох мөрөөдөлдөө автан Уди хаан Чанань хотоос 2500 км хол орших Давань луу их цэргээ хөдөлгөсөн байна. Ийнхүү тэдний цэргийн агт олох зорилгоор баруун хязгаар луу хөдөлгөсөн цэрэг нь баруун орныг Хань улсын хөнөөлд оруулах бололцоо олгосоноор тэд Хүннү улсын баруун хязгаарын ноёрхлыг тасалж чадсан байна. Ийнхүү тэд Хүннүгийн адууг “Ху-ын адуу”, Хөх нуур орчмоос олсон адууг “тэнгэрийн хүлэг”, Давань-аас олсон адуугаа “цусаар хөлөрдөг хүлэг” хэмээн нэрлэж байжээ.

¹ 汉书(han shu).第68卷.第2959.2960页

Цэргийн агтны соёл нь Хүннү улс болоод Хань улсын харилцааны нэгэн томоохон ололт юм. Хань улсын адууны соёлын үндэс нь Хүннү нараас үүдэлтэй бөгөөд тэд Модун шаньюйд бүслэгдсэн үйл явдлаас хойш адуу эрчимтэйгээр өсгөх болсоноор хэдэн зуу мянган морьт цэргээс бүрдсэн армитай болсон аж. Түүнчлэн Ханьчууд Хүннү улсаас адуу өсгөх, агт тэжээх, хооллох, уналга эдэлгээнд сургах зэрэг мэдлэгийг суралцсан хэмээн үзэж болох юм.

Abstract: The Han Dynasty experts and scholars payed great attentions and organized lots of studies on Xiongnu wars and soldiers, but specialized studies and essays about the Xiongnu military horse has not announced yet and much spread indirectly. This essay is made about the one purpose of the Han Dynasty's conquering plans. In the scope of above purposes, this essay will state the fights for the best breed of those horses of Barbarian, Lord knights and blood-honored horses.

Ном зүй

1. 司马迁《史记》(三家注), 中华书局, 1985年。
2. 班固《汉书》, 中华书局, 1962年。
3. 范晔《后汉书》, 中华书局, 1965年。
4. [日本] Sawada isao, 《古代游牧国家的兴旺-匈奴》, 呼和浩特, 2011年。
5. 《中国方术概观》上下册, 人民中国出版社, 1993年。
6. 《盐铁论译注》王贞珉注译 / 王利器审订, 吉林文史出版社出版, 1995年。
7. 《旧唐书》, 中华书局出版, 1975年。
8. Дэлгэржаргал, П. Батсайхан, З. Монголын эртний түүх: Хүннү. Тэргүүн боть. Улаанбаатар: 2017
9. Нацагдорж, Ш. Чингис хааны цадиг, Улаанбаатар: 1991
10. Руденко, С.И. Культура хуннов и Ноинулинские курганы, М-Л., 1962
11. Сүхбаатар, Г. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар: 1980